



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/430.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 04/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Швейцарийн хөгжлийн агентлаг, Байгаль орчин аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны төвөөс хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн боловсрол-2 төсөл хэрэгжиж байгаа аймгийн 4 сургуульд орон нутгийн оролцооны зардалд 30 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд зарцуулагдах 30 000 000 төгрөг /гучин сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 2.1 дэх "Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн орон нутгийн оролцоо" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 19-ний өдрийн
А/430 дугаар захирамжийн хавсралт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ТӨСЛИЙН
ОРОН НУТГИЙН ОРОЛЦООНЫ ЗАРДАЛ

Д/д	Байгууллагын нэр	Орон нутгийн оролцоо /төгрөг/
1.	Жаргалант сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	7 500 000
2.	Жаргалант сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	7 500 000
3.	Буянт сумын ерөнхий боловсролын сургууль	7 500 000
4.	Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургууль	7 500 000
	Нийт дүн	30 000 000

-оОо-